



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/379

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн гэрэлтүүлэг (Хутаг-Өндөр сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Анд Энерги" ХХК-тай 99,693,750 (ерэн есөн сая зургаан зуун ерэн гурван мянга долоон зуун тавь) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Анд Энерги" ХХК -ийн захирал (Ц.Гүррагчаа)-д даалгасугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010490

Аймгийн Засаг даргын 2021 оны
 05 дугаар сарын 24-ны/ний өдрийн 7/379 дугаар
 захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	1 679 002	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	1 679 002	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	839 501	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	151 110	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	3 000 000	Ү.Бямбасүрэн
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 50 хоног	Ү.Бямбасүрэн
7	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
8	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн